

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/22-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2024 он	Аудитор: Д.Чулуунцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

–	
1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. Аудитын тайлан	16-18
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Б.МӨНХЗУЛ ТАНАА

2024.02.20 № СЭН-2024/22-НН-СНА-ТЦУЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь орон нутгийн өмчийн эзэмшилд байсан татан буугдсан МХГ-ын 117,318.4 мянган төгрөгийн үнэ бүхий Ланд крузер 105 авто машиныг аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 121 дүгээр тогтоолын дагуу үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авч, бүртгэл тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Тайлант оны төсөвт НДШ-ийн зардлыг 14,652.1 мянган төгрөгөөр илүү төлөвлөн баталсныг оны эцэст төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант оны” Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 3 зорилтын хүрээнд 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 81.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Данс-ны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>70283126.16</u>	<u>58761381.44</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	728000.00	188000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	728000.00	188000.00
3121	Төгрөг	728000.00	188000.00
31211	Төрийн сангийн харилцах	728000.00	188000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	69555126.16	58573381.44
351	Түүхий эд материал	33243701.01	32903201.01
35110	Тусгай зориулалттай материал	33243701.01	32853701.01
35130	Эм боох материал	0.00	49500.00
354	Хангамжийн материал	36311425.15	25670180.43
35410	Бичиг хэргийн материал	1341470.00	1040200.00
35420	Аж ахуйн материал	16335380.00	11461140.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	0.00
35450	Барилгын засварын материал	0.00	0.00
35460	Хүнсний материал	7317761.22	2274049.60
35470	Бусад хангамжийн материал	11316813.93	10894790.83
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1173259750.38</u>	<u>1233226694.24</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1173259750.38	1233226694.24
392	Биет хөрөнгө	945455750.38	1005422694.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	939612572.98	939612572.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	-96701701.72	-120964803.76
39203	Авто-тээврийн хэрэгсэл	139500000.00	256818399.85
39204	Хуримтлагдсан элэгдэл	-128499999.84	-141362893.11
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	154106446.60	157324001.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83565925.60	-103132246.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34704867.00	34704867.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20280799.92	-23899861.59
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	3746324.00	3746324.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	3912000.00	3912000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1078033.12	-1335666.40
393	Биет бус хөрөнгө	227804000.00	227804000.00
39301	Програм хангамж	6417692.31	6417692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6417692.31	-6417692.31
39303	Бусад биет бус хөрөнгө	227804000.00	227804000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1243542876.54</u>	<u>1291988075.68</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1243542876.54</u>	<u>1291988075.68</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1243542876.54	1291988075.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	345578539.48	345578539.48
51101	Өмч: - төрийн	345578539.48	345578539.48
512	Хуримтлагдсан үр дүн	328418886.71	376864085.85
51210	Өмнөх үеийн үр дүн	328792680.71	328418886.71
51220	Тайлант үеийн үр дүн	-373794.00	48445199.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	569545450.35	569545450.35
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1243542876.54</u>	<u>1291988075.68</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	754263883.01	1170654118.61
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25712983.01	121433018.61
120	Нийтлэг татварын бус орлого	25712983.01	121433018.61
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25712983.01	121044754.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	872000.00	2710000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24840983.01	118334754.85
120009	Бусад орлого		388263.76
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	728550900.00	1049221100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	718750900.00	1049221100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	718750900.00	1049221100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9800000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9500000.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300000.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	754637677.01	1122208919.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	754637677.01	1122208919.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	753250692.75	1063714150.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	491998426.17	789864130.45
210101	Үндсэн цалин	330338871.96	456568174.00
210102	Нэмэгдэл	131199279.10	286789793.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24125000.00	26703163.00
210104	Урамшуулал	6335275.11	19803000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11143620.04	16606580.24
210201	Тэтгэврийн даатгал	568332.49	
210202	Тэтгэмжийн даатгал	53490.13	
210203	ҮОМШӨ-ний даатгал	66862.63	
210204	Ажилгүйдлийн даатгал	13372.56	
210205	Эрүүл мэндийн даатгал	10441562.23	16606580.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95788199.90	84152396.84
210301	Гэрэл, цахилгаан	11546958.90	13938553.84
210302	Түлш, халаалт	58126960.00	54259083.00
210303	Цэвэр, бохир ус	26114281.00	15954760.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31109466.13	34929668.66
210401	Бичиг хэрэг	5693510.00	4040220.00
210402	Тээвэр, шатахуун	9048996.00	12450000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1091575.13	868309.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210000.00	400000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15065385.00	17171139.10
2105	Нормативт зардал	43131008.28	45685715.62

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	870700.00	1579870.00
210502	Хоол, хүнс	40234620.28	44105845.62
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2025688.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24820100.00	20072280.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	195000.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	264600.00	250000.00
210604	Урсгал засвар	24360500.00	19822280.00
2107	Томилолт, зочны зардал	426000.00	2038000.00
210702	Дотоод албан томилолт	426000.00	2038000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3430214.00	7154152.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1869574.00	2189535.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	421724.00	225184.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110000.00	80000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	671500.00	4554500.00
210807	Газрын төлбөр	357416.00	104933.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51403658.23	63211226.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3250000.00	2642216.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48153658.23	60569010.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1386984.26	58494768.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	419980.00	43291800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		42331800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	419980.00	960000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	967004.26	15192968.67
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	967004.26	15192968.67
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	10000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		10000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-373794.00	48445199.14

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	729183895.74	1036738131.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1600000.00	2710000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1600000.00	2710000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	872000.00	2710000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	872000.00	2710000.00
120009	Бусад орлого	728000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	727583895.74	1034028131.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	717783895.74	1034028131.33
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	717783895.74	1034028131.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9800000.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9500000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	300000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	728455895.74	1037278131.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	728455895.74	1037278131.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728035915.74	993976331.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	492726426.17	789864130.45
210101	Үндсэн цалин	330338871.96	456568174.00
210102	Нэмэгдэл	151009779.10	286789793.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5042500.00	26703163.00
210104	Урамшуулал	6335275.11	19803000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11143620.04	16218316.48
210201	Тэтгэврийн даатгал	568332.49	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	53991.52	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	66361.24	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	13372.56	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10441562.23	16218316.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95788199.90	84152396.84
210301	Гэрэл, цахилгаан	11546958.90	13938553.84
210302	Түлш, халаалт	58126960.00	54259083.00
210303	Цэвэр, бохир ус	26114281.00	15954760.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27983425.63	26771370.56
210401	Бичиг хэрэг	5354050.00	3682750.00
210402	Тээвэр, шатахуун	9048996.00	12450000.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	992795.13	758044.56
210404	Ном, хэвлэл	300000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	210000.00	400000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12077584.50	9480576.00
2105	Нормативт зардал	46407650.00	40691504.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	829700.00	1629370.00
210502	Хоол, хүнс	45577950.00	39062134.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	46512100.00	24213980.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	22023000.00	4141700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	264600.00	264000.00
210604	Урсгал засвар	24224500.00	19808280.00
2107	Томилолт, зочны зардал	426000.00	2038000.00
210702	Дотоод албан томилолт	426000.00	2038000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3638294.00	7264417.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2077654.00	2299800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	421724.00	225184.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110000.00	80000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	671500.00	4554500.00
210807	Газрын төлбөр	357416.00	104933.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3410200.00	2762216.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3410200.00	2762216.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	419980.00	43301800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	419980.00	43,291,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	42,331,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	419980.00	960000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	10000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	10000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	728000.00	-540000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	728000.00	-540000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	728000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	728000.00	188000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/
төгрөгөөр
/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	328,758,083.89	1,243,916,670.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	328,758,083.89	1,243,916,670.54
C07	Тайлант үеийн үр дүн			-373,794.00	-373,794.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	328,384,289.89	1,243,542,876.54
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	328,010,495.89	1,243,542,876.54
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	328,384,289.89	1,243,542,876.54
D08	Тайлант үеийн үр дүн			48,445,199.14	48,445,199.14
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	345,578,539.48	569,580,047.17	376,829,489.03	1,291,988,075.68

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/Төгрөгөөр/	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,051,921,100.0	1,037,278,131.3	14,642,968.7	98.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,051,921,100.0	1,037,268,131.3	14,652,168.7	98.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,169,300.0	993,976,331.3	15,192,968.7	98.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,882,400.0	789,864,130.5	18,269.5	99.9
210101	Үндсэн цалин	456,194,500.0	456,568,174.0	(373,674.0)	100.8
210102	Нэмэгдэл	286,790,500.0	286,789,793.5	706.6	99.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,094,400.0	26,703,163.0	391,237.0	98.5
210104	Урамшуулал	19,803,000.0	19,803,000.0	-	100
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,425,500.0	16,218,316.5	14,207,183.5	53.3
210205	Эрүүл мэндийн даатгал	30,425,500.0	16,218,316.5	14,207,183.5	53.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	84,160,100.0	84,152,396.8	7,703.2	99.9
210301	Гэрэл, цахилгаан	10,950,000.0	13,938,553.8	(2,988,553.8)	127.2
210302	Түлш, халаалт	57,626,100.0	54,259,083.0	3,367,017.0	94.1
210303	Цэвэр, бохир ус	15,584,000.0	15,954,760.0	(370,760.0)	102.3
210304	Байрны түрээс			-	
2104	Хангамж, бараа материалын зардал	26,772,500.0	26,771,370.6	1,129.4	99.9
210401	Бичиг хэрэг	3,536,500.0	3,682,750.0	(146,250.0)	104.1
210402	Тээвэр, шатахуун	20,108,500.0	12,450,000.0	7,658,500.0	61.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,655,000.0	758,044.6	896,955.4	45.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	272,500.0	400,000.0	(127,500.0)	146.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.0	9,480,576.0	(8,280,576.0)	79
2105	Нормативт зардал	40,703,900.0	40,691,504.0	12,396.0	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,629,700.0	1,629,370.0	330.0	99.9
210502	Хоол, хүнс	39,074,200.0	39,062,134.0	12,066.0	99.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,214,600.0	24,213,980.0	620.0	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,141,700.0	4,141,700.0	-	100
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	264,600.0	264,000.0	600.0	99.7
210604	Урсгал засвар	19,808,300.0	19,808,280.0	20.0	99.9

2107	Томилолт, зочны зардал	2,171,600.0	2,038,000.0	133,600.0	93.8
210702	Дотоод албан томилолт	2,171,600.0	2,038,000.0	133,600.0	93.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,838,700.0	7,264,417.0	574,283.0	92.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,324,600.0	2,299,800.0	24,800.0	98.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.0	225,184.0	174,816.0	56.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.0	80,000.0	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,672,400.0	4,554,500.0	117,900.0	97.4
210807	Газрын төлбөр	361,700.0	104,933.0	256,767.0	29.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.0	2,762,216.0	237,784.0	92.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,000,000.0	2,762,216.0	237,784.0	92.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,751,800.0	43,291,800.0	(540,000.0)	101.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,751,800.0	43,291,800.0	(540,000.0)	101.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,331,800.0	42,331,800.0	-	100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	420,000.0	960,000.0	(540,000.0)	100.5
2135	Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт		10,000.0	(10,000.0)	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		10,000.0	(10,000.0)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,051,921,100.0	1,036,738,131.3	15,182,968.7	101.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,049,221,100.0	1,034,028,131.3	15,192,968.7	101.4
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,049,221,100.0	1,034,028,131.3	15,192,968.7	101.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,700,000.0	2,710,000.0	(10,000.0)	100.3
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,700,000.0	2,710,000.0	(10,000.0)	100.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		728,000.0		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		188,000.0		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0		100
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0		100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	36.0	35.0		97.2
620001	Удирдах ажилтан	1.0	1.0		100
620002	Гүйцэтгэх ажилтан	33.0	32.0		96.9
620003	Үйлчлэх ажилтан	2.0	2.0		100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	36.0	35.0		97.2
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	36.0	35.0		97.2

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь /Сэлэнгэ аймаг дахь ШШГГ/ “Шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дэлхий нийтээр мөрдөж байгаа эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлж, олон улсын жишигт хүргэх, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэх” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газар нь үйл ажиллагааныхаа чиглэлийг дараах байдлаар тодорхойлон, хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалах энэхүү үүргийг бүрэн хэрэгжүүлэх,
- Цагдан хорих, таслан сэргийлэх үйл ажиллагааг хүний эрхийг дээдлэн, хүний амьдрах эрүүл ахуйн шаардлага, стандартад нийцүүлэн хуулийн дагуу хэрэгжүүлж ажиллах,
- Хорих болон хорихоос өөр төрлийн ялыг албадан эдлүүлэх, сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих тухай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, эрүүгийн ялын зорилтыг хангах,
- Иргэний, захиргааны зөрчлийн болон эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын анги, салбар нэгжийн барилга байгууламж, ахуй нөхцөлийг сайжруулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.17, 11 дүгээр зүйл, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс гэснийг Эрүүл мэндийн магадлалын зөвлөл гэж өөрчилсөн,*
- *Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*

- Монгол улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 488 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Монгол улсын засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.
- Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/235 дугаар тушаалын хавсралтаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл” шинэчлэн батлагдсан,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хяналт хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тайлант онд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШШГЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар ШШГЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан

бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,445.2 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	728.0	188.00	- 540.0
Бараа материал	69,555.1	58,573.3	-10,981.8
Үндсэн хөрөнгө	1,173,259.7	1,233,226.7	59,967.0
Нийт хөрөнгө	1,243,542.8	1,291,988.0	48,445.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,243,542.8	1,291,988.0	48,445.2

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 58,573.3 мянган төгрөг болж 10,981.8 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдлээс тайлант онд зарцуулсантай холбоотой байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,233,226.7 мянган төгрөг болж 59,967.0 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор 117,318.4 мянган төгрөгийн Ланд крузер 105 авто машиныг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авч бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 953,304,2 мянган төгрөгөөр, өөрийн орлогоос 2,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцон нийт зардлыг 955,304.2 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Улсын төсвөөс олгох санхүүжилтийг 95,916.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,049,221.1 мянган төгрөгөөр, өөрийн орлогын төлөвлөгөөг 700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,700.0 мянган төгрөгөөр, нийт орлогыг 96,616.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж цалингийн зардлыг нэмж санхүүжүүлэхээр төлөвлөн нийт зардлыг 1,051,921.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,049,221.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 2,700.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос, нийт 1,051,921.1 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,049,221.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 2,710.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, оны эхний дансны үлдэгдэл 728.0 мянган төгрөг нийт 1,052,659.1 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж урсгал үйл ажиллагаанд 1,037,278.1 мянган төгрөгийг зарцуулж, 15,203.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,037,278.1 мянган төгрөг буюу 98.7 хувьтай тайлагнагдсан нь НДШ-ийн зардлын хэмнэлт 14,652.1 мянган төгрөг, дансны оны эхний болон эцсийн үлдэгдлийн зөрүү 540.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны давсан орлогын 10.0 мянган төгрөг зэрэг нийт 15,203.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа	996,919.3	982,267.2	14,652.1	98.6
2	Туслах үйл үйл ажиллагаа	2,700.0	2,710.0	10.0	100.3
3	Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа	8,375.4	8,375.4	-	100
4	Холбооны суваг ашигласны төлбөр	1,174.6	1,174.6	-	100
5	Нэг удаагийн тэтгэмжийн зардал	42,751.8	42,751.8	-	100
	Дүн	1,051,921.1	1,037,278.1	14,663.0	98.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын Төрийн сан дахь 100130012405 тоот дансанд орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй болно.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Хоригдол, хоригдогч нарын хоол хүнсний материал нийлүүлэх	39,074.2	39,074.2	Харцуулалт 4377143999
	Нийт дүн	39,074.2	39,074.2	МНОА0065 9055436

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг 2 удаа зохион байгуулсан боловч оролцогч санал ирүүлээгүй тул Номуун Сэлэнгэ ХХК, Алтантариа ХК, иргэн О.Оюун Эрдэнэ нартай хүнс, хангамжийн материал нийлүүлэх гэрээг тус тус байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шилэн дансны мэдээлэл болон ХХОАТ-ын хөнгөлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.


Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/107 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 754.637.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,546.3 мянган

төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэлээ.



4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь ШШГГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүд бусад арга хэмжээнүүдтэй холбогдуулан аялал зугаалга, уралдаан тэмцээн зохион байгуулаагүй зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймаг дахь ШШГГ-ын мэдээлбэл зохих 20 төрлийн 167 мэдээллээс 162 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт / 8 дугаар сарын мэдээлэл /,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /8 дугаар сард/,
- Аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан / 7 дугаар сар /
- Дараа жилийн төсвийн төсөл / 9 дүгээр сар /
- 2023 оны санхүүгийн хагас жилийн тайлан.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд өгсөн зөвлөмжийн биелэлтийг холбогдох баримтын хүрээнд тулган шалгахад 100 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	4,013.5	3	4,013.5	100
Нийт дүн	3	4,013.5	3	4,013.5	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 382.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөвлөмж хүргүүлэв.

5.1 Зөвлөмж


1. Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Албан хаагчдад олгосон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулалд ногдуулсан албан татварын жилийн хөнгөлөлтийг оны эцэст хуульд заасан хувь хэмжээгээр тооцоогүйгээс 10 албан хаагчийн жилийн албан татварыг 70.0 мянган төгрөгөөр илүү, 22 албан хаагчийн албан татварыг 312.0 мянган төгрөгөөр дутуу зэрэг нийт 382.0 мянган төгрөгийн ногдуулсан байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх “Албан татвар төлөгчийн ... орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ”, 25 дугаар зүйлийн 25.7 дахь “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1.2 Өгсөн зөвлөмж: ХХОАТ-ыг хуулийн дагуу ногдуулан, хөнгөлөлтийг жилийн эцэст тооцох, татварын байгууллагатай тооцоо нийлж, дээрх зөрүүг арилгах.



6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Татварын хөнгөлөлтийг жилийн эцэст тооцоогүй.	1	382.0					1	382.0				
Дүн	1	382.0					1	382.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	5							5
Дүн	5							5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	5							5